УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**Ч. Далай**

# МОНГОЛ, ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ТҮҮХИЙН АСУУДЛААС (XII-XV ЗУУН)

XIII зууны үеийн Монголд феодалын түрүү үеийн байгуулал янз бүрийн хэлбэрээр ахин хөгжсөн нийгэм-эдийн засгийн байгуулалтай аймаг, аймгийн холбоод болон ханлигууд Хятадын Цагаан хэрмээс хойшхи өргөн уудам нутгийг эзэгнэн оршсоор байжээ. Тэр үед Хятадын өмнөд хэсэгт Сүн улс, умарт, зүүн хойт хэсэгт Зүрчид угсааны Алтан улс[1], Тангуд угсааны Си Ся улс[2] тус тус оршин тогтнож ерөнхийдөө Хятад нь дотроо нэгдэн нийлээгүй хуваагдмал байдалтай байв. Тухайн үед Монгол, Хятадын хооронд үе үе их бага хэмээний дайн дажин, уулга дээрэм явагддаг байсан нь хоёр улсын ард түмний хүсэл эрмэлзлэлээс шалтгаалсан хэрэг огт биш байлаа. Тэр бүхэн нь юуны өмнө монголчуудыг хүний олны давуу хүчээр түрээ барьж түрэмгийлэн довтлох буюу өөр хооронд нь яс хаяж хутган мөргөлдүүлж байгаад хүчийг нь сулруулах замаар эрх ноёрхолдоо оруулах гэсэн хятадын ноёлогч ангийн уламжлалт бодлого, нөгөө талаар үе үе Хятадын зүг уулга дээрэм довтолгооныг үүсгэн хийдэг байсан монголын ноёлогч язгууртан ангийн бодлогоос ихэвчлэн үүдэн гардаг байжээ.

Нөгөө талаар монгол, хятад хоёр улсын аль алинд нь хэрэглэж буй аж ахуйнхаа бүтээгдэхүүнийг харилцан арилжаалах хэрэгцээ тухай тухайн үедээ их байжээ. Тийм ч учраас түүхээс монгол, хятад хоёр улсын хооронд харилцан ашигтай арилжаа худалдаа хийх явдал нэн чухал асуудлын нэг байсаар иржээ. Өгүүлэн буй үед Монгол улс нь гадаадын худалдаачдын дур сонирхолыг ихэд татдаг мал аж ахуйн бүтээгдэхүүнээр баялаг орны нэг байжээ. Нөгөө Хятад улс нь гурил будаа, бөс даавуу зэрэг өргөн хэрэгцээний бараагаар элбэг, тэр бүхнээсээ гадагш наймаалж, түүхий эд олж авахыг ихэд эрхэмлэн хүсдэг орон байжээ.

XII зууны сүүлч XIII зууны эхээр Монголын нэгдсэн төр байгуулагдаж, улмаар дундад эртний феодалын түрүү үеийн нүүдэлчдийн хүчирхэг улс болсон юм. Тэр нь хятадыг тойрсон нүүдэлчид хэзээ ч биеэ даасан улс төр байгуулж өөр хоорондоо нэгдэн нийлж чадахгүй гэж үздэг байсан Хятадын эзэрхэг төрийн хаад, язгуууртнуудын үндсэрхэх дээрэнгүй үзэл бодлогод үнэхээрийн том цохилт болсон юм.

1 Зүрчид угсааны Алтан улс (манжаар Айсин гүрэн) 1115 онд байгуулагдсан. Агуда хаан (1149—1189) 1158 онд Алтан улсын нийслэлийг Чжунду-д (Бээжингийн дэргэд) нүүлгэн авч ирж, хүчирхэг гүрэнг байгуулсан. Мадаху Чун хэй (хятадаар Юньцзи 1209-1212) хааны үед Алтан улсад Монголчууд дайн зарласан, 1234 онд Алтан улсыг монголчууд бүрмөсөн эзэлж, Алтан улс мөхсөн.

2 Тангуд угсааны Ся улс 1032 онд байгуулагдсан. Дараа нь удсангүй баруун Тангуд (хятадаар Си Ся) нэртэй болсон байна. 1038 онд улсынхаа нэрийг Да Ся (их Тангуд улс) хэмээн нэрлэжээ. Энэ бол Төвд улс мөн. Тэд хятадын баруун хойт нутгийн зарим хэсгийг эзэлж байв.

XIII зууны эхэн хагаст Чингис тэргүүтэй монголын феодалууд гадагш түрэмгий дайныг үүсгэн хийж, дэлхийн олон улс орныг байлдан эзэлж, түр зуур монголын их гүрэнг байгуулав. Тийм нөхцөлд хятадын феодалууд монголчуудыг нэгэнт хүчээр дийлж хэзээ ч чадахгүйг мэдсэн учир арга залийг хослон хооронд нь мөргөлдүүлэх, хүн амын олноор түрээ барьж уусган хайлуулах замаар монголчуудын хувь заяаг шийднэ гэж үздэг хэзээ язаанаасаа баримталж ирсэн улигт бодлогодоо эргэн оржээ. XIII зууны дунд үеэс хятадын төрийн бичгийн язгууртан нар монголын хаадад Хятадын эзэрхэг хаадын хэрэглэж байсан «хааны цол», «оны цолыг» хуурамчаар хэрэглүүлэн, улмаар түүнийгээ түүх судартай бичих болжээ. Энэ бүх байдал Хубилай хаан Юан гүрнийг байгуулснаар бүр ч тодорхой болсон юм.

Хубилай хааны дэргэд номын багш нэртэйгээр ажиллаж байсан зарим хятад бичгийн түшмэлийн ярьж хийж байсан ажил явдлаас тухайн үед Монголчуудыг хятадчилах гэсэн хятадын талын санаа оролдлогыг мэдэж болох байна.

Монголчууд хятадын умарт нутгийг эзлэн захиран баримталж байх үед Кунцзын сургаалтан Чжао Би[3], Бан Ө[4], Яо Шу[5], Лю Бянь-чжун[6], Хао Цзин[7] зэрэг олон бичгийн түшмэл үйлчилж, Күнзын сургаалын ном зохиол, Хятадын түүх намтраас орчуулан Хубилайд өргөн танилцуулж байжээ. Тэд Монгол, Хятад нэгэн шашинтай байж, Күнцзын шашныг монголд дэлгэрүүлэхийн ач холбогдлыг сурталчлан ярьдаг байжээ. Мөн Монгол улсын нийслэлийг Бээжингээр төвөлж, монгол хятад нэгэн засаг төртэй байхыг хүртэл ятган ухуулж байсан байна. Жишээлбэл: Хятад бичгийн түшмэл Чжао Би нь Мөнх хааны үеэс эхлэн Монголын хаадын итгэлийг ихэд олжээ: Хубилай хятад түшмэл Чжао Би-г нэрээр нь дууддаггүй «авъяастан» хэмээн дуудаж, түүгээр номын багш болгож, эрдэм ном заалгаж байсан хэмээн тэр үеийн сурвалжид тэмдэглэсэн байдаг. Нэг өдөр Мөнх хаан Чжао Би-г дуудан уулзаад «Улс гүрэнг хэрхэн захиран тохинуулах бол) хэмээн асуухад тэрээр «Ойр дотныхоо хүмүүс дотроос урвагч муу санаатнуудыг юуны өмнө устгавал зохих биз»[8] хэмээн хариулжээ. Түшмэл, Чжао Би монгол бичгийн хэл сайтай байснаас Хятад хэлнээс ачлалт ном, шашинт ном зэрэг күнцзын сургаалын олон номыг монголоор орчуулж Хубилай тэргүүтэй Монголын феодалуудад уншуулж, номын агуулгыг цаг мөч бүр тайлбарлаж өгдөг байжээ.

Түшмэл Ван Ө бол, хятад даяар ихэд нэрд гарсан Күнцзын сургаалтан хүн байжээ. Нууц товчоог хятад хэлээр орчуулах ажлыг анх санаачлан хийсэн хүн байж магадгүй. Гэвч түүнийг нарийвчлан судлууштай. Тэрээр Хубилайд кунцзын сургаалыг “харь улс оронд дэлгэрүүлэхийн ач холбогдлыг байнга зөвлөн ярьж, Күнцзын сургаалын ном зохиолоос бас тайлбарлан өгдөг байжээ. Тэрээр «төрийн хэргийг барихдаа Күнцзын сэргаалын энэрэнгүй үзлийг дагах ёстой» гэж монголын хаад, ноёдод байнга зөвлөж байжээ. Гэтэл тухайн байдлыг ажиж үзвэл түшмэл Ван Ө-гийн зөвлөсөн «Күнцзын сургаалын энэрэнгүй ёс» гэгчийн цаана улс төрийн нарийн бодлого нуугдаж байсан нь илт байна.

3 Хубилай хятад газар хамгийн анх Чжаб -Би-тэй танилцаж түүнийг номын багшаар дэргэдээ авчээ. Энэ хүн бол хятад нэртэй дагуур монгол гаралтай хүн байж магад байна. Гэвч одоогоор тодорхой нотолгоогүй. «Юань шиг-(Юан улсын судар»-ын 159-р бүлэгт энэ хүний дэлгэрэнгүй шастир бий.

4 «Юань-ши» 157-р бүлэг

5, 6, 7, Мөн тэнд.

8 «Юань-ши» 159-р бүлэг

Хятад түшмэл Хао Цзин. Хубилай хаантай уулзаж ярилцах бүр монголын Их хааны ширээг булааж авах аргыг зааж зөвлөж байжээ. Үүнийг Хятадын түүхчид өөрийнхөө зохиолд нуухгүй бичсэн байдаг. Энэ тухай хятадын түүхчин Шан Юэ бичсэн нь: «Хубилай хятад бичгийн түшмэл Хао Цзиний саналаар Монголын хуралдааны хаан сонгох хуучин ёс журмыг эвдэж 1260 онд өөрөө хаан болсон»[9] гэжээ.

Түшмэд Лю Бин-Чжун бол Монгол улсын нийслэлийг хятадад шилжүүлэн нүүлгэх ажлыг санаачлан хийж, Хархорум-тай өрсөлдөгч хот Кайпиныг барих зураг төсөл боловсруулжээ.[9]

Монгол хүн хятад орныг хэрхэн захирах тухай засаг төрийн зохион байгуулалтыг Лю Бин-чжун, Сюй Хэн нар төлөвлөж «ли чжэн-и» - (төр барих санал) гэдэг нэртэйгээр 1271 онд Хубилайд өргөн барьсанд түүнийг ёсоор болгож хэрэгжүүлжээ.[10]

XII—XIII зууны үед Хятадын Күнцзын шашин маш их эрч хүч олж, зэргэлдээ улс орондоо нөлөөгөө түргэн дэлгэрүүлсээр байжээ. Яг ийм үед хятад бичгийн түшмэд ч Хубилай тэргүүтэй монголын феодалуудад Күнцзын сургаалын «давуу талыг» ятган ухуулах ажлыг завсар зайгүй хийж эхэлжээ. Гэвч Хубилай хаан тухайн үедээ үндэснийхээ эрх ашгийг эрхбиш зөвөөр ухаарч хятад түшмэлийн шашны номнолоор дамжуулан амархан хяталчилах гэсэн арга мэхэнд автаагүй байна. Ийм ч учраас Хубилай хаан Күнцзын шашны нөлөөг Монголд дэлгэрүүлэхээс болгоомжилж, зан заншилд нь нэг их харшилмааргүй буюу Күнцзын шашны нөлөөг бүрэн хааж чадах хүчтэй бурханы шашныг хүлээн авч улсын гол шашин болгожээ. Хэдийгээр бурханы шашин монголд дэлгэрч монголчуудын оюун санааг машид эзэмдэн хүчин чадлыг нь бууруулж, дарлан мунхруулж байсан хэдий боловч түүхийн тодорхой хугацаанд Күнцзын шашны түрэн уусгах нөлөөг шууд хаах, хятадчилах бодлогонд хаалт болж байсан байна. Ийм ч учраас XIII — XIV зууны үед Хятадын зүгээс Монголд эдийн боловсролын зүйл нилээд нэвтэрч байснаас биш, шашин, соёлын нөлөө асар их гүнзгий нэвтрээгүй байдаг нь тийм учиртай ажээ.

Ер нь монголчууд дээр үеэс өөрийн улс орны бие даасан, тусгаар тогтносон байдалд харшилж болохуй гадны улс төр, үзэл суртлын аливаа нөлөөнөөс үргэлж болгоомжилж, түүнээс зайдуу оршихыг цаг ямагт эрмэлзэж иржээ.

Юан гүрнийг байгуулснаар Монголын хаад харь олон улс орныг захиран барим-талсан их гүрний далай хаад болжээ. Тэр үед монгол нь «эзэн улс, хятад нь эзлэгдсэн улсын байдалтай байжээ.

Юан гүрний үед тулгар төр мандсан монгол нутагт монгол улсын гол хүч хэвээр байж, Хархорум хот нь урьдын адил Монголчуудын улс төрийн төв болсоор байсан байна.

Хубилай хаан уугал монгол орны засаг засмалд анх эхлэн өөрчлөлт хийхдээ юуны өмнө бүх монголыг захирах алтан тамга барьсан хаан хөвгүүнийг тохоон томилжээ. Өөрөөр хэлбэл Хубилайн үеэс хаан хөвгүүний эрх үүрэг их болж, түүний ажил төрөл нь тодорхой болжээ. Хаан хөвгүүнийг урьдаас тохоон томилдог нь нэгэн талаар хаан ширээ булаалдах тэмцлээс сэргийлсэн тал байвч, нөгөө талаар үндсэн монгол орныхоо төрийн хэргийг бариулах гэсэн учиртай байжээ. Хубилай бол Юан гүрний Далай их хаан, Хаанхөвгүүн бол бүх Монголын хэргийг ерөнхийлөн захи-

9 «Юан-ши», 157-р бүлэг,

10 Хао Цзин. «Линь чуан вень-цзи» (Линь чуаний түүвэр зохиол» 32-р бүлэг. Шанхай., 1337 он.

рах хан байсан байна. Хубилай хааны үед тогтсон энэ журам Юан гүрний эцэс хүртэл хэвээр байжээ.

Хубилай хааны тогтоосон ёс журмаар бол ширээ залгах хаанхөвгүүн заавал Хархорумд сууж бүх Монголын төрийн хэргийг ерөнхийлөн барихаас гадна хаан төрийн ёсонд биеэ боловсруулах, цэрэг захирах давхар үүрэгтэй байжээ. Юан гүрний үед монгол цэргийн гол хүч заавал Хархорумын орчимд байдаг байжээ. Хархорум төвтэй Монгол орон тэр үед эх нутгаа хамгаалж чадах цэрэг эрийн хүчтэй байсан байна. Хубилай хаан Монголын нийслэлийг Хятад оронд шилжүүлсэн нь уудам газар нутагтай, үй түмэн хүн ам бүхий хятад орныг захиран баримтлах шаардлагаас үүдэн гарсан мэт боловч, эцсийн үр дагавараараа Монголын улс төр, эдийн засгийн хөгжилд айхтар сөрөг нөлөө үзүүлжээ.

Юан гүрний үед Монголын феодалууд Монголын ард түмний хүсэл эрмэлзлэлээс өчүүхэн ч хамаарахгүйгээр Хятадыг байлдан эзэлж, төрийн эрхийг нь 100 шахам жил барих хугацаандаа хятадын ард түмнийг улс төр, эдийн засгийн талаар дарлан мөлжиж амьдралын ноцтой байдалд хүргэж байсныг монголын марксист түүхчид үргэлж зэмлэн буруушаадаг. Тухайн үед монгол хаадын төрийн бодлогын үндсэн чиглэл нь гол төлөв нүүдэлчин аймгуудын хүчинд дулдуйдан суурьшмал хүн ардыг тухайлбал гүрний хүн амын дийлэнх хэсэг болох Хятадын ард түмнийг эзэрхэн ноёрхох явдал байжээ.

Тэр цагийн сурвалжид «хятад хүнийг зодвол хариу өшөө авч болохгүй»[11], «хятад хүн монгол хүнийг зодвол хариуг дуртайгаар авч болох бөгөөд алж болно»[12], «хулгай хийсэн хятад хүнийг эхний удаа зүүн мөрөн дээр, хоёр дахь удаа баруун мөрөн дээр, гурав дахь удаа хүзүү дээр нь тус тус үсэг шивнэ»[13], «Шоронд суусан хятад хүн хоол хүнсээ өөрөө даана»[14] «хятад хүн биедээ зэвсэг мэс хэрэглэж болохгүй»[15], «Хятад хүн олноороо цуглаж ярьж болохгүй»[16], «100 хятад хамтарч ан хийвэл цаазлана», «100-гаас доош бол алс хол цөлнө»[17] гэх мэтээр бичсэн байдаг. Энэ байдлаас үзэхэд Монголын байлдан дагуулагчид хятадын ард түмнийг хэрхэн дарлаж байсан нь нэн тодорхой ажээ. Ийм ч учраас хятадын ард түмэн үргэлж бослого хөдөлгөөн гаргадаг байжээ. Тухайлбал зөвхөн 1283 онд Монголын ноёрхолыг эсэргүүцсэн өмнөт хятадын 200 гаруй газарт ард түмний том жижиг бослого хөдөлгөөн гарч байжээ.

XIII-XIV зууны үеийн олон бичиг сурвалж, тухайн үеийн бичгийн түшмэд Ма Цзу-чан (1279—13441), Вэн Тянь-сян (1236— 1282) Сян Юй шу (1300-оны үе) Юю Цзе (1311—1375), Най Сянь (1350 оны үе), Ван минь (1320 оны үе) гэх мэт олон хүний зохиол, шүлэгт Юан гүрний үед монголын феодалууд хятадын ард түмнийг хэрхэн дарлан мөлжиж амьдралын ноцтой байдалд байлгаж байсан байдлыг бас тодорхой баримтаар тусган харуулсан байдаг.

Юан гүрний үеийн түүх, тэр үеийн монгол-Хятадын харилцааны байдлыг дэлхийн эрдэмтэн мэргэд түүний дотор хятадын түүхчид янз бүрээр тайлбарлан өөрсдийн үзэл бодлыг илэрхийлсээр ирэв. БНХАУ-ын түүхчид ч бас янз бүрийн үзэл санаагаар тайлбарлаж байв. Жинхэнэ марк-

11 «Юань дянь-чжан». — («Юан улсын хууль цаазны бичиг»), 28-р бүлэг.
12 Мөн тэнд, 27-р бүлэг
13 Мөн тэнд, 21-р бүлэг
14 Мөн тэнд, 59-р бүлэг
15 «Юань-ши» 9, 12, 15, 17-р бүлэг.
16 «Нэвтэрхий хууль», 57-р бүлэг,
17 Ма Цзу-чан, «Ши Тянь-цзи» («Ши Тяний зохиолын эмхтгэл») 7-р бүлэг.

сист-ленинист түүхчид бол аливаа байлдан дагуулагчдын үйл ажиллагааг ард түмний эрх ашгийн үүднээс, ангийн байр сууринаас авч үзээд түүнд марксист үнэн зөв шинжилгээ дүгнэлт өгсөн байх ёстой билээ. Иймээс Юан гүрний үед Монголын байлдан дагуулагчид хятадын ард түмнийг дарлан мөлжиж байсныг үгүйсгэж ясан ч болохгүй нь мэдээж. БНХАУ-ын түүхчин Фань Вэнь-лань[18], У Хань[19], Ван Чун-у[20], Шан Юэ[21], Юй Юань-ань[22], нарын зохиолд Юан гүрний үеийн түүхийг нилээд бодит үзэл санаагаар дүгнэн бичсэн байдаг. Гэтэл 1961 оноос хятадын түүхчид XIII-XIV зууны Монголын түүхийг шууд мушгин гуйвуулж, их гүрний үндсэрхэг дээрэнгүй үзлийн үүднээс тайлбарлан бичих болов. Энэ талаар ЗХУ-ын нэрт Хятад судлаач С. Л. Тихвинский «Ази Европ дахь Татар-Монголын байлдан дагуулал» хэмээх эрдэм шинжилгээний доривлог өгүүлэлдээ маш тодорхой баримтаар дүгнэн бичсэн байна.[23] Хятадын зарим түүхчид Монголын хаадын байлдан дагуулал, ард түмнийг дарлан мөлжиж байсан ажиллагааг ямар ч шүүмжлэлгүйгээр магтан сайшааж, зарим талыг нь өрөөсгөлөөр хэт дэвэргэн үнэлж байна. Тэд өөрсдийн зохиолд «Тэр үед монголчууд хятадын «Өндөр хөгжилтэй соёлын» шууд нөлөөнд байсан»[24], «Хятад биш үндэстнийг нэгтгэсэн Чингэс хааны хувьсгалч үзэл санаанаас суралцая»[25] «Чингэс хаан хятадын олон үндэстний хоорондын заагийг арилгаж, Хан, Тангаас нааш байгаагүй улс байгуулж, Хятадын түүхэнд дэвшилт үүрэг гүйцэтгэсэн»[26], «Манай нэгдсэн олон үндэстний улсын хөгжилд Хубилай гарамгай их хувь нэмэр оруулсан»[27] гэх мэтээр бичиж байжээ. Энэ бол түүхийг марксист түүхчдийн байр сууринаас биш, зөвхөн их гүрний дээрэнгүй үзлийн байр сууринаас дүгнэж бичсэн хэрэг даруй мөн.

Юан гүрний үед Монголын хаад хятадын ард түмнийг дарлан мөлжих хатуу хууль дүрэм тогтоож байснаас гадна монголчуудынхаа талаар бас нарийн хууль дүрэм тогтоожээ. Жишээлбэл: Хятад орныг захиран баримтлах хэргээр 400 мянга шахам монгол хүн хятад нутагт 100 жил суухад хятад хүнтэй гэр бүл болоогүй байна. Тэр үед, монгол хүн хятад хүнтэй ураг барилдахийг хуулиар чандлан хориглосон байжээ. Жинхэнэ төрийн алба хаасан бичгийн түшмэл хүнээс бусад хүмүүс буюу гэр бүлийн монгол хүн хятад нутагт хятадаар ярих ёсгүй байжээ. Мөн хятад газар суугаа монгол хүн хятад тариачидтай хамтран тариалан тарих буюу бусад ямар нэгэн хар ажил хамтран хийж болохгүй ажээ. Монгол газар хя-

18 Фань Вэнь-лань. «Чжунго тунши цзяньбянь» - ( «Хятадын ерөнхий товч түүх») Шанхай., 1949. 455—505»),
19 У Хань. «Юаньдай чжи шэху» — «Юан гүрний үеийн нийгэм»), «Шэхуй кэсюэ» т. 1. 1936. № 3.
20 Ван Чун-у. «Лунь Юань-мо нун-минь ци-и» —{«Юаний сүүлчийн тариачдын бослогын нийгмийн байдал») «Лиши яньцзю», 1954. № 1. 53-71-р хуудас.
21 Шан Юэ. «Чжун-го Ли-ши гаи-яо» — «Хятадын түүхийн товч») Бээжин, 1954. 260-р тал.
22 Юй Юань-ань. «Чэнцзисы хань чжуань», («Чингэс хааны намтар») Шанхай, 1956. 85—97-р тал.
23 С. Л. Тихвинский. «Татаро-монгольские завоевания в Азии к Европе» (Вступительная статья) «Татаро-Монголы в Азии и Европе» Москва., 1977. 3-22-р тал
24 «Жэньминь жибао», 1961. VII 10.
25 «Цзефан жибао» 1942. V. 6.
26 «Жэньминь жибао» 1962. VIII—10.
27 «Гуэнминь жибао» 1962-1-21.

тад тариачид, очиж газар хагалбарлахыг бүр хуулиар чандлан хорьсон байна. Тэр ч байтугай монгол, хятад хүүхэд хамтран тоглож болохгүй хуультай байсан байна. Энэ бүхэн нь хэдийгээр монголын байлдан дагуулагчдаас хятадын ард түмнийг дарлан мөлжиж, ард түмнүүдийн хооронд дайсагнасан ажиллагаа явуулж байсан явдал хэдий мөн боловч уул хэргийн явцыг бүх талаар нарийвчлан судалж үзвэл монголын феодалууд Хятадад уусан хайлахаас болгоомжилж байснаас тийнхүү хатуу хууль тогтоох байсан талтай ажээ.

Чжу Юан-чжан-аар удирдуулсан хятадын тариачдын бослогын цэрэг 1368 оны 8-р сард Хаанбалгасан (Бээжин хотыг эзлэн авснаар Юан гүрэн үндсэндээ мөхөж, хятадад монголын байлдан дагуулагчдын ноёрхол эцэс болсон билээ. Хэрэв 1260 онд умарт хятадыг эзэлснээс эхлэн тоолбол 108 жил, 1271 онд Юан гүрэнг байгуулснаас эхлэн авч үзвэл 97 жил, 1279 онд Өмнөт Сүн улсыг байлдан эзэлж бүх Хятад орныг захирснаас эхэлбэл 89 жил монголчууд Хятад орныг эзлэн ноёрхож байжээ.

Монголын эзэнт Юан гүрэн хэдийгээр мөхсөн боловч, Монгол улс, монголын төр мөхөөгүй юм. Монголын Юан гүрний сүүлчийн их хаан Тогоонтөмөр 1368 онд эзэнт гүрний төрийг алдаж хятадаас зугтааж гарсны дараа монгол нутагтаа ирж, Монгол улсын төрийн хэргийг үргэлжлүүлэн барьжээ.

Тогоонтөмөр хаан Хятадаас хөөгдөхийн өмнө Хятад нутгаар бутран тархсан монголчуудыг хураан цуглуулж, эх нутагт нь буцаан нүүлгэх ажлыг яаравчлан хийжээ. Гэвч хятадын Мин улсын засгийн газар монголчуудыг тархсан газарт нь хэвээр барин суулгах хатуу хууль гаргаж, дүрвэн буцан нүүснийг нь зам зуурт хядан устгаж байжээ. Ийм байдлын дунд хятадын өмнөт газраар сууж байсан ихэнх монголчууд нутагтаа буцаж ирж чадсангүй. Хятадын Мин улс байгуулагдмагц «Татар монгол хүнийг хүйс тэмтрье», «дайралдсан газар татар (монгол) хүнийг алж, олдсон газар татар бичигтэй цаас устга», «8-р сарын 15-ны еэвэн сарыг өргөн тэмдэглэж монголын толгойг хагал», «монголчуудыг цэргийн хүчээр довтолж хүйс тэмтрэн устга» гэх мэт харгис уриа лозунг хятад даяар цуурайтуулжээ.

Мин улсын хаанаас Тогоонтөмөрт сүр далайлгасан захиа явуулж, хятадын харьяанд шууд бууж өгөхийг шаарддаг байжээ. Нөгөө талаар төрийнхөө уламжлалт тамгыг Хятадын хаан монголын хааны гараас эргүүлж авахыг хүсч байжээ.

Энэ талаар жишээ болгож нэг захиаг авч үзье. Мин улсын хаан Чжу Юан-Чянан-аас 1369 онд Тогоонтөмөр хаанд өгсөн албан захидалд дурдсан нь: «Би бол угаас харин иргэн хүн. Ойрноо улсын дотоодод давшил үгүй үймээн самуун ихтэй болов. Дээрэмчид газар сайгүй гарч, иргэний газрыг таслан авч, ард олныг аюул зовлонд учруулж байгааг хараад тэвчин сууж эс чадав. Эрхэм ч гэсэн тэднийг хориглон барьж чадахаа байжээ. Тэд гаднаа Юан гүрний даамал түшмэл мэт боловч, дотроо үргэлж хар, хүйтэн санаа өвөртлөх болжээ. Эмх замбараагүй бослого хөдөлгөөнийг дарж, ард олныг амар жимэр байлгахыг бодох хүн нэг ч үгүй болжээ. Иймээс би биеэрээ жанжнуудаа дагуулан... найман мин (муж), хоёр мөрнийг өөрийн харъяат нутагт оруулсан. Гэтэл эрхэм минь... улсынхаа төлөө санаа тавихгүй... Өөр хоорондоо алалцан тэмцэлдэж ард олныг зовлонд учруулсаар ажгуу. Иймээс уржнан жил их жанжнаа умарт газарт явуулав. Гэтэл миний цэрэг хүрээгүй байхад, өвөг дээдсийнхээ орд харшийг орхиод, эрхэм минь нэгэнт буруулан явсан байлаа. Би бодохдоо эрхмийг монголын зуу хүрэхгүй жилийн хувь заяагаа дууслаа гэдгийг ухаа-

ран мэдээд, тэнгэрийн тааллыг дагаж хятадын хуучин нутгийг буцаан өгч байна гэж машид сайшааж байлаа. Гэтэл удсан ч үгүй эрхмийг Кайпины Шанду-Ч.Д) зүг байн байн уулгалан довтолж байна хэмээн харуулын сэргийлэх жанжнууд илтгэн мэдээлэх болов. Эрхэм минь урд өмнө орд харт амгалан, улс гүрнээ чинээлэг байх үедээ тэр олон дээрэмчдийг дарж чадаагүй байж, одоо говьд очоод байн байн хил рүү аюул учруулж байгаа нь эрхмийн юмыг алсад бодохгүй ухвар мөчдийн хар гай биз. Одоо Хятадын бүх нутаг миний эрхэнд орж нутаг даяар хэдийн тохинон, харь ястан цөм захирагджээ. Хэрэв би умарт этгээдэд тэрэг гарган довтлон тэр чигээрээ Ин Шан уулын умар зүгт хүрээд очвол эрхэмд хэдийгээр зуун түмэн ард иргэн байлаа ч гэсэн унтарч байгаа галын цог, ус нь хатсан голын загас мэт болсон болохоор яахин ингэж болох билээ. Эрхэм та хэдийгээр умарт этгээдэд зугтаан одовч очих газар даан ч байхгүй биз ээ. Би эрхмийг өөрийн байдлыг өөрчлөн хувь заяагаа шийдэж үг дуугүй дагавал сая удам угсаагаа хамгаалж чадна гэдгийг чин үнэн санаанаас зөвлөе. Эрхэм минь үүнийг сайтар тунгаан соёрхоно уу»[28] гэжээ.

Захианы байдлаас үзэхэд Мин улсын хаан сүрхий ёс сахисан мэт дур үзүүлсэн мөртлөө ихэд бардамнан сүр далайлгасан болох нь илэрхий байна. Энэ нь Мин улсын хаан өөрийн түрэмгий бодлогыг цагаатгаж байсан нэгэн талын оролдлого мөн болохоос гадна тэр монголчуудын хүчийг амархан цохиж, эрхэндээ бүрэн оруулж болно гэж бодож байсныг гэрчлэн харуулж байна. Гэвч тухайн үеийн бодит байдал тийм амархан биш байжээ. Нөгөө талаар захианы дотор монголчууд л уулга дээрэм эхлэн сэдэж Хятад улсын «Кайпин» зэрэг нутгаар довтолсон мэтээр дурджээ. Тэр үед Шанду (Кайпин) хот бол монгол хот, тэр хавийн газар бол цөмөөр монголчуудын газар нутаг байсныг Мин улсын цэрэг түрэмгийлэн эзэлж, дарангуйлан сууж байв. Гэтэл Дандуг эргүүлэн авахаар довтолсныг яахин хятадын нутагт түрэмгийлэн халдсанаар үзэх билээ. Захианы хамгийн сүүл хэсэгт Тогоонтөмөр хааныг албат ардаа авч, үг дуугүй бууж өгөхийг шаарджээ. Ийм шаардлагыг эрх чөлөө, тусгаар тогтнолоо батаар сахин хамгаалж ирсэн монголын ард түмэн хэзээ ч хүлээн авахгvй нь мэдээж хэрэг. Ард түмний эсэргүүцэл тэмцлээс болгоомжилсон Тогоонтөмөр хаан ч чингэхийг эс зөвшөөрөн хариу захиа илгээсэнгүй ажээ. Захианы дотор Юан гүрнийг Хятадын төр улс биш, монголын төр улс байсан гэдгийг Мин улсын хаан албан ёсоор зөвшөөрөн хүлээж байжээ.

Ийм үед Тогоонтөмөр хаан монгол цэргийн гол хүчийг бөөгнөрүүлж хятадын Мин улсын хааны айлган сүрдүүлэх бодлого, тvрэмгийлэн халдах довтолгооноос сэргийлэн хамгаалах, эзэгнэн ноёрхож байсан Хятадын зарим нутгийг алдахгүй барьж, бололцоо гарвал бас цааш нь эзлэн авах бодлого явуулж байжээ. Өмнөд Хятадын Юаньнань, Дорно умартын Ляодуны хойг Сычуань, Шэньси, Ганьсу, зэрэг муж газар орны зарим хэсэг нь 1381 он хүртэл монголчуудын захиргаанд байсан юм. Ийм нөхцөлд Тогоонтөмөр хаан Монгол улсыг «Ар Юан» хэмээн нэрлэсэн байна.

Тогоонтөмөр хаан «Ар юан» улсын төрийг бататгах, газар нутгийг цаашид тэлэн өргөтгөх, Монгол цэргийн бүх хүчийг төвлөрүүлэх зэрэг ажлыг сэдэн хийж байгаад шинэ барьж байгуулсан Барс хот, нийслэл Хархорумд очиж чадалгүй 1470 онд нас эцэслэжээ. Тогоонтөмөр төрийн хар тамгыг чандлан хадгалж, хятадын Мин улсад хэрхэвч бууж өгөхгүй, улс орноо мандуулахыг үр ач нартаа захиж хаан ширээ залгамжлах эрхийг хүү Аюушридарт өгчээ.

28 «Сюанлан тан цуншу сюйцзи» 96-р бүлэг. Татарчуудад өгсөн захидал гэдэг гарчигтай хэд хэдэн чухал захиа бий.

Тогоонтөмөр хаан нас барж үй их гашуудал үйлдэж хөл үймээнтэй байх үеэр нь гэнэдүүлэн Мин улсын тусгай сургуулилсан морин цэргийн анги Инчаныг довтолж Монголын хааныг тамгын хамт олзлон авахыг зорьжээ. Гэвч хятадын түрэмгий цэрэг Тогоонтөмөр хааны хүү Майдарбалыг олон хүний хамт олзлон авснаас биш, Монголын хааныг барьж чадсангүй. Монголын их хаан ширээнд суух Аюушридар хятадын түрэмгий цэргийн бүс лэлтийг сэт тохиж бараа бологсодынхаа хамт Инчанаас явж монголын Баарин нутгийн Цагаан суварганд хэсэг суугаад улмаар хойш явж Хархорумд хүрэлцэн ирж нийслэллэн сууҗээ. Монголын хааныг гэнэдүүлэн баривчлах гэсэн Мин улсын хааны түрэмгий төлөвлөгөө тийнхүү нурсан байна

Ингэж Монгол улсын их хаан төрийнхөө тамгыг авч 110 жилийн дараа буюу 1370 онд уугуул нийслэл Хархорумд хүрэлцэн ирснээр Монгол улсын төрийн төв харь орноос эх нутагтаа бүрмөсөн шилжиж ирсэн түүхтэй. Энэ нь Монголын өргөн олон түмэн үндсэн нутагтаа гал голомтоо сахин амьдарч байсны зэрэгцээгээр, нийслэлээ буцаан авчирах гэж 100 гаруй жил санаа тавин тэмцсэн тэмцэлтэй шууд холбоотой. Энэ үеэс Хархорум хот улам өнгө жавхаа, нэр хүндтэй болж, дахин нийт монголчуудын улс төрийн төв баттай болов. Яг энэ үеэр Хятадын Мин улсын феодалууд Монголд довтлон орж Хархорум хотыг түргэн хугацаанд сүйтгэн сөнөөх хорт явуулгыг бас хийж эхэлжээ.

Мин улсын Чжу Юан-чжан хаанаас Аюушридар хаанд монголчуудыг сүр далайлган айлгах гэсэн бодлогоо урьдын адил үргэлжлүүлж бас хэд хэдэн удаа албан захидал илгээжээ. Түүний 1370 онд илгээсэн гуравдахь Захианы дотор дурдсан нь: «Түрүүний хоёр удаа элч зарж, захидал илгээсний хариу одоо хүртэл сураг алга. Магадлан үзвэл эрхмийн гаж буруу бодлогоос болжээ. Эрхмийн санаа бол ертөнцийн эзэн би болохоор түүний доторхи ард иргэд бас минийх байх ёстой хэмээн үзэж байна. Гэтэл ёс журмын дагуу хэлэлцвэл тийм бишээ эртний үгэнд ард бол ус, хаан бол завь, ус бол завийг дээш хөвүүлж ч чадна, доош хөнгрүүлж чадна гэж байдаг. Гэтэл эрхэм минь үүнийг мэдэхгүй, эрэгнүүлэн ухаарахгүй зөрүү зан гаргаж юунд эс буцаж ирнэм. Өнөөдрийн явдлаар үзэхэд эрхмийн түшиг баатруудад байгуулсан гавъяа өчүүхэн ч алга. Миний цэрэг өдрөөс өдөрт хүчирхэгжиж байхад эрхмийг хуучин байдлаараа байхыг хэрхэн зөвшөөрөх ажээ. Эзэн тэнгэрээс нэгэнт заяаж хайрласан эдүгээгийн байдлыг хэрхэн хүч зоригоор өөрчлөн шийдэх билээ. Эрхэм минь юунд зальхай этгээдүүдийн үгэнд орж, гуньж гомдон суунам. Түргэн эв түнжин тогтоож, тэнгэрийн ёсыг таалж, хүний ёсыг дагавал эрхмийн харьяаны аймгуудад миний зарлиг хүчин төгөлдөр болох биш бил үү. Тэр цагт эрхэм минь гүрний дотор эзэгнэн захирсан нэг эзэн нь болж өвөг дээдсээ хүндлэн тахиж явах эрхтэй үлдэнэ. Хэрвээ энэхүү байдлыг үл хайхран үлдсэн цөөхөн хүчээрээ хил хязгаар довтлон үймүүлэх ахул өөрт чинь аюул тулгарана. Би зургаан их жанжныхаа удирдсан цэргийн бүх хүчийг говь нутагт хөдөлгөн оруулах болно. Тэрхүү цагт эрхэм минь харамсал илэрхийлэн гуйвч цаг нэгэнт оройтсон байх болно»[29] гэжээ.

Захианы агуулгаас үзэхэд Мин улсын хаан хүчээр сур далайлган монголчуудыг басамжлан доромжилж, бууж өгөхийг тулган шаардаж хэрэв бууж өгөхгүй бол цэргийн хүчээр түрэмгийлэн эзлэх гэдэг бодлого үргэлжлүүлэн явуулсаар байсан нь харагдаж байна. Нөгөө талаар захидал нь Мин улсаас Монголыг түрэмгийлэн довтлох шалтаг эрсэн хэрэг байжээ. Аюушридар Хятадын хааны албан захидалд ямар ч хариу өгөөгүй ажээ.

29 Мөн тэнд, 98-р бүлэг.

Билэгт хаан Аюушридар, Хөхтөмөр жанжин нар Мин улсын цэрэг довтлон ирнэ гэдгийг урьдчилан мэдэж Хархорумын цэлгэр хөндийгөөр цэргээ сургуулилж, агт морио амрааж нилээд сайн бэлтгэжээ. Хөхтөмөр бол хятад газар олон удаа байлдаан хийж, ялалт байгуулж явснаас гадна хятад цэрэгтэй байлдах аргыг сайн мэддэг байжээ. Хятад цэргийн хоол хүнсийг таслан эзлэх, гэнэт дайрч сандралд оруулах, түр ухарч зугтаад эргэж цохих зэрэг аргыг тэр хэрэглэж байжээ. Хятадын хаан захиа илгээснээсээ хойш жил гаруй хугацаа өнгөрсний дараа 132 онд Сюй Да, Ли Вань-чжун нарын 2 жанжнаар удирдуулсан хятадын 15 түмэн цэргийн их хүчийг монголд цөмрөн оруулжээ. Хятадын цэрэг Монголын хангайн уулын ард их сүржнээр хорооллон буудаллажээ. Хятадын харгис цэрэг монголчуудыг цохиж эрхэндээ оруулж улмаар Хархорум хотыг эвдлэн сөнөөх зорилготой иржээ. Гэвч Хөхтөмөр жанжин цэргээ авч тосон байлдаж дайсны цэргийг хиар цохижээ. Мин улс байгуулагдсаар хятадын цэрэг анх удаа хамгийн том ялагдал хүлээжээ. Мин улсын Чжу Юан-чжан хаан ч Хөхтөмөр жанжны удирдсан монголын цэргийн хүчин чадал их, Монголыг хүчээр дийлж болохгүй гэдгийг арга буюу зөвшөөрөн хүлээжээ[30]. Энэ үеэс нэг хэсэгтээ Мин улсын цэрэг монгол газар довтлохыг зүрхэлсэнгүй.[31]

Хөхтөмөр, Мин улсын үлдэгдэл цэргийг нэхэн хөөж бутцохиж яваад Алтайн уул хүрч, Хар нохойн зоо гэдэг газар 1373 онд нас баржээ.[32] Хөхтөмөр хэдийгээр Юан гүрний нэрт жанжин монголын феодал ангийн төлөөлөгч байсан боловч насны эцэст ийнхүү эх монгол нутгаа харийн дайсны халдан довтлохоос хамгаалж, төрийн тусгаар тогтнолын төлөө амь хайрлахгүй тэмцэж байгаад амь үрэгдсэн төр, цэргийн зүтгэлтний нэг мөн. Монгол нутагт гүнээ цөмрөн орж ирсэн хятадын 150000 цэргийн Их хүчийг Аюушридар, Хөхтөмөр нар тийнхүү бутцохиж, улс орноо авран хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн нь түүхэнд зүй ёсоор тэмдэглэгдэн үлджээ.

1373 оноос хойш хэсэг хугацаанд Монгол-Хятадын хооронд нэг их дайн дажин болсонгүй, амар жимэр байдалтай байжээ.

Хятадын Мин улсын зүгээс нэг талаар олзолж аваад хүч аргыг хослон өөрийн нөлөөнд татан оруулсан Майдарбалыг Монголын хаан болгох, нөгөө талаар Монголын дорнод, баруун үндсэн хоёр хүчийг хооронд нь мөргөлдүүлж дотроос нь хүчийг задлах ажлыг идэвхтэй хийжээ.

Майдарбалыг буцааж Хархорумд хүргүүлэхэд Чжу Юан-чжан-аас Аюушридарт бас захиа илгээж дурдсан нь: «Урьд, эрхмийн Инчанд орхисон балчир хүүгий чинь би өмнөд газар авч ирүүлээд ихэд хүндэтгэлтэйгээр байлгаж таван жил шахам болов. Чамайг бодож үзэхэд говь нутгаар хэсүүчлэн хойт үеэ залгамжлах хүн байхгүйд зовогнон буйг ойлгоод тусгай элч томилж хүндэтгэлийн ёсоор хамгаалуулан буцааж Юан гүрний удам угсааг тасалдуулахгүй залгамжлуулахыг бодсон бөлгөө. Эрхэм минь энэ бүхнийг сайтар тунгаан соёрхоно уу»[33] гэжээ.

Энэ байдлаас үзэхэд Майдарбалыг хаан суулгаж, өөрийн талд шуул, ашиглах гэсэн оролдлого болох нь юуны өмнө илт байна. Нөгөө талаар Майдарбалыг хамгаалан хургэж ирж байна хэмээх нэрийдлээр олон элч илгээж. Монголын байдлыг тагнан туршихыг зорьсон байжээ.

30 «Мин Шк». («Мин улсын судар») 124-р бүлэг.

31 Юй Баян. «Өвөр Монголын түүхийн товч найруулал» Шанхай., 1958. 65-р тал.

32 БНМАУ-ын түүх тэргүүн боть. 415-р тал.

33 Сюань-лань, «тан цуншу сюйцзи», 96-р боть.

1378 онд Аюушридар ҳаан нас барахад монгол ноёдын ихэнх нь Майдарбалыг хаан суулгахаас эрс татгалзаж Мин улсад бууж өгөхгүй гэдэг үзлийг хатуу баримталж байсан Төгстөмөрийг[34] хаан ширээнд суулгажээ. Үүнээс болж Мин улс Монголыг дахин дайтаж эхлэв. Төгстөмөр хаан Мин улсын цэрэг довтлон ирнэ гэдгийг мэдэж, Хархорум, Инчан хоёр хотоор төвлөж цэргийнхээ хүчийг дахин дахин нэмэгдүүлж байжээ. 1380 онд Мин улсын МУ Ин  жанжнаар удирдуулсан их цэргийн хүч монголд довтлон орж, Хархорумыг дайрч эвдэн сүйтгэсний дараа монгол газар удаан суувал байдал хүнд болохыг мэдэж нилээд их эд, агуурс, мал сүрэг дээрэмдэн авч буцжээ.[35] Энэ үеэс Төгстөмөр хаан голдуу Инчан хотод төвлөн суух болсон нь дайсны цэргийг монгол нутгийн гүнд цөмрөх оруулахгүй тосон байлдах гэсэн бодлого байснаас гадна түүнд Хархорум хотоо дайны талбар болгохгүй хамгаалах гэсэн эрмэлзлэл бас байсан бололтой.

1381 онд Мин улсын жанжин Сюй Да, фу Ю-дэ нарын удирдсан их цэргийн хүч Монголын ордос нутгаар довтолж хүн ардыг алж, ихээхэн дээрэм хийжээ. 1382 онд Му Ин жанжны удирдсан Мин улсын цэрэг Юньнаньд орж, тэнд үлдсэн монголчуудын хүчийг цохиж эрхэндээ оруулжээ. Юньнань бол Юан гүрний үед Хятадын өмнөт нутгаар сууж байсан монгол цэргийн төв нь байв. Хятадын Мин улс байгуулагдсанаас хойш 10 гаруй жил Юньнаний монголчууд тусгаар байдлаа хамгаалан бууж өгөхгүй тэмцсээр байжээ. Гэвч тэд үндсэн монголтойгоо холбоо тасарч, хүч сэлбэх боломжгүй болсон учир эцсийн эцэст арга буюу хятадын цэрэгт бууж өгчээ.

Төгстөмөрийн хаанчлалын үед монголчууд Мин улсын довтолгооныг удаа дараа бутцохиж няцааж эх нутгаа хамгаалж эрх тэгш харилцсаар байжээ. Мин улсын хаан монголчуудтай байлдах ажлыг монгол угсааныг жанжин Му Инд хариуцуулсан байжээ. Их удаан хугацаагаар бэлтгэл хийсний дараа 130 мянган цэргийн их хүч Инчан хотыг дайрчээ. Маш ширүүн тулалдаан болж хоёр тал их хохирол үзжээ. Яг байлдааны дундуур Му Ин жанжин 20 мянган шилдэг морин цэргийн хүчийг авч шөнийн цагаар гэнэт Төгстөмөр хааны ордыг дайрсан боловч Төгстөмөр хаан, их хүү, бараа бологсдын хамт төрийн тамгаа авч зугтаан явж амжжээ. Мин улсын цэрэг хаан хүү, хааны хатан, төрийн сайд ноёд, 2900 гаруй хүн, бас 7700 гаруй хүн ард, 150000 толгой малтай олзолсон гэж Мин улсын сударт сүр бадруулан бичсэн байдаг.

Монголын хааныг олзлох гэсэн Мин улсын хааны төлөвлөгөө ийнхүү нурсан юм.

Хятадын түүх сударт Төгстөмөр хааны нас барснаар «Ар Юан» улс мөхөж, Юан гүрний хаадын жинхэнэ угсаа тасраад ерөөс Монголын төр эцэс болсон мэтээр бичсэн үзэгдэнэ. Гэвч уг байдал тийм биш, Төгстмөр хааны дараа ч гэсэн Монголын төрийн уламжлалт огт тасарсангүй, Эх, Элбэг, Гүнтөмөр, Буняшир гэх мэт хаад удаа дараа Монгол улсын төрийг барьжээ.

Хятадын Мин улсын Юн Лэ (1403-1424) хааны үед хоёр улсын хоорондын улс төрийн харилцаа ихэд хурцадсан юм. Юн Лэ хаан бол Монголыг таван удаа довтолж монгол газар дайн хийж яваад нас нөхцсөн хүн.

34 Төгстөмөр бол Тогоонтөмөр хааны 2-р хүү Аюушридарын хүү мөн Хятадын Мин улсад бууж өгөхгүй гэдэг бодлогыг хатуу баримталж байжээ.
35 «Мин улсын судар», 126-р бүлэг.

1409 онд Юн Лэ хааны илгээсэн их цэргийн хүч Монголд нэвтрэн орж Буняшир хааны цэрэгт байлдан бут цохигджээ. Гэвч энэ үед Буняшир хааны цэрэг их хохирол хүлээснээс чадал хүч нь нилээд сульдсан байжээ. Буняшир хаан цэргийнхээ хүчийг сэлбэж тэнхрүүлж чадаагүй байтал Юн Хэ хаан дахин довтолжээ. Энэ бол 1410 онд Юн Лэ өөрийн биеэр 50 түмэн их цэрэгтэй довтолсон дайн бөгөөд Юн Лэ хааны таван удаагийн дайны анхдугаар нь юм. Тэр үед Буняшир хаан түүний тэргүүн сайд Аругтай ноёны хооронд зөрчил гарч монгол цэргийн хүч хоёр хуваагджээ.[36] Буняшир хаан, Аругтай түшмэлийн хятадад бууж өгөх гэсэн оролдлогыг хатуугаар зэмлэн буруушааж, монголын тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэхийг заан сургажээ. Тэр хоёрын хооронд тийм зөрчил гарсныг Хятадын Мин улс нэгэнт тагнан мэдсэн байжээ.

1410 онд Юн Лэ хааны удирдсан хятад цэрэг Монголын нутгийн гүнд цөмрөн орж, Онон голын хөвөөнд Буняшир хааны цэрэгтэй байлдсанд Буняшир ялагдаж, хаан төрийн тамгаа өвөртлөн долоон баатраа дагуулан Ойрад монголд зугтаан очсон билээ. Түүнтэй хамт явсан долоон баатарын дотор түүний дүү Дэлбэг явсан байна. Мин улсын үеийн сурвалж бичгийн зарим хэсэгт Буняшир хааныг Ойрадын Махамуд ноён алсан, зарим хэ сэгт Буняшир хаан ердийн үхлээр үхсэн гэх мэтээр бичсэн байдаг. Уг хэргийн байдлыг судалж үзвэл Буняшир хаан ердийн үхлээр үхсэн бөгөөд нас барахаасаа өмнө Ойрадтай хүн хамтран хятадын Мин улсын түрэмгийллийн эсрэг тууштай тэмцэхийг Дэлбэг, Махамуд нарт захиж үлдээсэн шиг байна.

Хятадын феодалуудын хутган үймүүлэх бодлогоос болж Ойрадын Махамуд ноён 1409 оноос түр зуур хятадын Мин улсын талд орсон нь үзэгдэнэ. Түүнээс болж Дорнод Монгол, Ойрад монголын хооронд зөрчил сүрхий хурцадсан байна. Энэхүү зөрчлийг Мин улсын феодалууд бас л овжин ашиглаж, хэргийн явцыг улам дэвэргэн монголын эл хоёр үндсэн хүчийг эвдрүүлэхийн тулд зальхай муу арга бүхнийг хэрэглэжээ. «Хятадын зүгээс Монголын хааны угсаа биш Махамуд ноён Буняшир хааныг хорлон алав», «Одоо Аругтайг алах гэж байна» хэмээх цуурхалыг дорнод Монголын дотор шуугиулан тарааж амжжээ. Үүнээс болж монголчуудын дотор ихэд үймээн самуун дэгдэж, цаг төрийн байдал нэг л бишдэх тийшээ ханджээ. Тэр үед нэгэн хааны захиргаанд Монголын нэгдмэл байддыг хадгалж барих нь Ойрад монгол, Дорнот монголын нийт олон түмний хүсэл мөрөөдөл мөн байв. Гэвч ард түмний эрх ашгаас уравсан феодалын хоорондын тэмцлээс болж монгол улсын төрд хямрал үргэлжлэн учирсаар байв. Ийм байдалд хятадын зүгээс ассан гал дээр улам ч их тос асган дүрэлзүүлж байж,

1410 онд Буняшир хааны цэрэг ялагдсан гол шалтгаан бол Хятадын довтолгооноос гадна Аругтай ноёны урвалт, бас Ойрадын феодалууд Буняшир хааны эсрэг тэмцсэн явдлаас болжээ. Гэтэл хятадын зүгээс Махамудыг дэмжихдээ зөвхөн цэргийнх нь хүчийг нь түр зуур Буняширийн эсрэг ашиглах гэснээс биш түүний бүх монголын эзэн болох гэсэн ажиллагааг нь дэмжээгүй юм. Бүх монголын эзэн болох гэсэн Махамудын санаархалаас Мин улс их болгоомжилж Буняшир хааны тэргүүн сайд Аругтайтай нууц холбоо барьж Махамудын эсрэг тэмцэх гэсэн байна.

1414 онд Махамуд ноён Аругтайг байлдахаар Хэрлэнд хүрэлцэн ирэхэд нь Юн Хэ хаан биеэр цэрэг авч Аругтайд туслахаар хөдөлжээ. Үүнийг Махамуд мэдэж гурван түмэн морин цэргээ авч угтан байлджээ. Тэр үед Мин улсын цэрэг галт зэвсэг, их буу хэрэглэсэн учир нилээд амжилт ол-

36 БНМАУ-ын түүх. Тэргүүн боть, 421-р тал,

сон авч хоёр талдаа хохирол их хүлээжээ.[37] Тэр үеэс Ойрад монголыг зонхилогч Махамуд хятадын Мин улсын эсрэг тууштай тэмцэл хийсний зэрэгцээ Мин улсад урваж, хуйвалдаан байгуулсан Аругтай ноёны эсрэг нэгэн зэрэг тэмцжээ. Гэвч удсангүй. Махамуд нас барж түүний хүү Тогоон эцгийн тэмцлийг үргэлжлүүлэв. Хэргийн ийм байдлаас Аругтай, Тогоон хоёр хоорондоо цус урсган тэмцэлдэж, хятадын Мин улсын идэш болж, монголын тусгаар тогтнол нэгдмэл байдалд ихээхэн аюул занал учруулжээ.

Юн Лэ 1422 онд гуравдахь удаагаа Монголыг довтолж, маш их мал хөрөнгө дээрэмдэн буцжээ.[38] 1423 онд дөрөв дэх удаагаа их цэрэг авч Аругтай ноёнын цэрэгтэй хамтран Ойрадыг байлдсан боловч нэг их амжилт олоогүй билээ. Энэ байдлаар Ойрад дахин босохгүй болтол ялагдав ҳэмээн судрт бичжээ. Гэтэл хойтон жил нь Юн Лэ хаан дахин Ойрадтай байлдан хүчин тэнцэж байжээ. Зарим үед хятадын судрын мэдээ авцал даагүй байдаг нь ийм бөлгөө. Хятадын түүх судрт Юн Лэ хаан монголчуудыг дайтан дарж номготгох хэрэгт их гавьяа байгуулж, монголын цэргийг үзэгдсэн газарт нь үнсэн товрог болтол цохисон мэтээр бичжээ. Гэтэл монгол хятадын феодалуудын хоорондын дайны явцаас үзвэл хэргийн байдал тийм биш, хоёр талын хүч аль аль нь их хохирол хүлээж, монгол улсын цэргийн хүч нь шинээр тогтсон хятадын Мин улсынхаас дутуугүй байсан нь олон талын баримтаар бүрч нотлогдож байна.

Тэр үед монгол улс нь явган цэрэггүй, цөөн тоотой боловч дан морин цэрэгтэй байсны учир хятад цэргээс байлдааны чадвараар арай илүү давуу талтай байжээ. Монголын морин цэрэг нь байлдааны нарийн тактиктай байгаа, ялангуяа дайны явцад ухарч зугтаад гэнэт эргэж цохидог байжээ. Гэтэл хятадын судар түүхэнд энэ бүхнийг ялагдаад зугтааснаар бичсэн нь үзэгдэнэ. Ер нь хятад ёсонд хааны биеэр командалсан цэрэг ялагдсан ч ялснаар бичдэг жамтай билээ. Иймээс хятад сурвалжийн мэдээг нарийвчлан судалж, бусад орны түүхийн баримт материалтай эрхбиш харьцуулан үзэх нь зүйтэй.

Юн Лэ хаан монголын хаадад сүр далайлгасан бичиг захиа бариулсан элч зарсаар байжээ. Тухайлбал Буняширийн хаан суусны дараа Юн Лэ хаан зарлиг бүхий бичигтэй яаралтай элч зарж хэлүүлсэн нь: «Монголын сүр хүчин доройтож Шүнь ди (Тогоонтөмөр) хааны үр Аюушридараас Гүнтөмөр хүртэл зургаан түмний дотор хаан суугаад бие биеэ маш түргэн солилцож тайвнаар нас эцэслэсэн хүн нэгхэнбээр үгүй хэмээн би сонслоо. Тайцзу (Чжу Юан-чжан) хаан, Юан гүрний үрсийг гүнээ өршөөн үзэж дагаж орохыг хүсэгчдийг найр тавин явуулсаар байв. Хаан Төгстөмөрийг суллан явуулсныг өмнө умрын хүн цөм мэднэ. Би монголчууд та нарыгаа үнэхээр эцэг нь хөвгүүнээ энэрэн үзэхтэйгээ яг адил бөлгөө. Одоо Юан гүрний шууд угсаа дахин хаан суув. Шудрагыг гүйцэтгэн номхоноор дагах, эсэх нь та нарын жаргал, аж төрөх буюу мөхөх сөнөхөд хамаарагдах болно. Сайтар тунгаан бодогтун» [39] гэжээ.

Гэвч Буняшир хаан, Мин улсын хааны айлган сүрдүүлэх бодлогоос өчүүхэн ч айж эмээсэнгүй, биеэ даасан бодлогыг тууштай баримталсан хэвээр байжээ. Тэр ч байтугай Мин улсын Юн Лэ хааны онц элч Го Цзингийн хууль бус шаардлагаас айхгүй түүнийг барин авч алсан байна. Го Цзи бол Юн Лэ хааны дотнын хүн байж, Буняширт бичиг авч ирээд бууж өгөхийг шаардаж, хэл амаар доромжилж догшин аашилсан ажээ. Хэр-

37 «Шуйюй Чжоуцзы лу», 17-р бүлэг.
38 «Мин улсын судар», 327-р бүлэг.
39 Мин улсын судар, 127-р бүлэг.

гийн иймэрхүү байдлаас болж Хятадын Мин улсын Юн Лэ хаан өөрийн биеэр их цэрэг авч монголыг таван удаа довтолсон боловч амжилт олоогүй болохыг дээр нэгэнт өгүүлсэн бөлгөө.

Мин улсын айлган сүрдүүлэх бодлого, цэргийн хүчээр байлдан дагуулах гэсэн оролдлого ийнхүү тухай бүр нэг их амжилт олоогүй байсан боловч хятадын зүгээс монголчуудын талаар ихээхэн хортой бодлогыг үргэлжлүүлэн явуулсаар байжээ. Энэ нь өөр хоорондоо нь байлдуулах, ноёдод хэргэм зэрэг олгох, хээл хахууль өгөх, нууцаар тагнах, хорооож алах зэрэг ажиллагаа болно. Ер нь тэр үед хятадын Мин улсад аюул занал учруулж болох гадны хүч Монгол улс хэвээр байсан нь илэрхий бөгөөд хятадын түүх судартч гэсэн хүнийг нуухгүй байгаа юм.

Мин улс монголчуудаас хамгаалах зорилгоор нийслэл хотоо Нанжингаас Бээжинд шилжүүлэн нүүлгэсэн билээ. Бас Цагаан хэрмийн дагуу «есөн хязгаар» гэдэг есөн том бэхлэлтийг байгуулан үлэмжхэн тооны дарангуй цэрэг суулгажээ.

Энэ бүхнээс үзэхэд тухайн үед Монгол улсын сүр хүч хятадын Мин улсаас нэг ч их дутуугүй, хоёр улс биеэ даан эрх тэгш харилцан байсан нь илэрхий ажгуу.

Ойрад монголын угсааны дөчин дөрвөн хоёрыг нэгтгэсэн Эсэн (1440-1455) хаан Хятадын Мин улсын хаан Ин Цзуны командалсан олон түмэн цэргийг бүтцохиж, 1449 оны 8-р сарын 15-нд хятадын эзэн хааныг олзлон барьж авсан билээ. Хятадын Мин улсын ноёрхогчид хааныгаа олзлуулсны дараа ихэд тэвдэн сандарч, эл хэргийг удаан болтол ард түмнээсээ нуусан юм. Хятадын хааныг монголчууд жил шахам хугацаагаар хорьж байгаад буцааж өгсөн түүхтэй. Гагцхүү энэ баримтаас үзэхэд л Монгол нь Мин улсын хараат улс байсан мэтээр нотлон бичдэг Хятадын үндсэрхэх үзэлтэй түүхчид болон хөрөнгөтний харгис түүхчдийн худал хуурмаг нотолгоонд няцаалт болох юм.

XII—XV зууны Монгол-Хятадын харилцааны түүхэнд олон янзын сайн муу үйл явдал гарч байсан боловч тэдгээрийн ихэнх нь ноёрхогч ангийн эрх ашгийн үүднээс хийгдсэн дайн дажин, уулга дээрэм байжээ. Иймээс хоёр улсын хоорондын улс төрийн харилцаа тухайн үед ихээхэн хурцадмал байдалтай байжээ. Гэвч энэ нь хоёр улсын ард түмний найрамдалт харилцааны түүхийг бүрмөсөн үгүйсгэсэн хэрэг огт биш байлаа. Хэргийн эх үүсвэр нь хоёр орны ноёрхогч анги, ялангуяа хятадын феодалынх ноёрхогч ангийн их гүрний дээрэнгүй, түрэмгийлэх бодлоготой шууд уялдан гарч байсан байна.

**Ч. Далай**

МОНГОЛО-КИТАЙСКИЕ ОТНОШЕНИЯ
(XIII-XV вв.)

## Резюме

В статье рассматривается история монголо-китайских отношений в XIII—XV вв. в етсной увязке с историей единого монгольского государства и с последующими событиями в жизни монгольского народа.

В начале XIII века монголы населяли свои исконные земли на общирной территории к северу от Великой Китайской стены. В те времена по-

литические отношения между Китаем и Монголией в основном характеризовались частыми грабительскими набегами друг на друга, большими и малыми военными конфликтами, противоречившими интересам народов двух стран. В те времена китайские правители проводили свою традиционную политику разъединения и подчинения монголов.

Однако, образование единого монгольского государства в начале XIII в. явилось сильным ударом по захватнической политике китайских императоров. Более того, в результате завоевания Китая монгольскими захват чиками, там установилось монгольское господство в лице Юаньской династии. Это было трудным периодом в истории китайского народа.

После крушения Юаньской династии Монголия оставалась самостоятелной, а Каракорум, как и прежде, был политическим центром монголов.

Характерно то, что до начала 60-х годов среди историков КНР существовало полное единодушие в оценке монгольского владычества в Китае, как эпохи чужеземного гнета и притеснения китайскими феодалами-военноначальниками и бюрократами, перешедшими на службу к завоевателям, об этом свидетельствуют многие работы таких видных историков, как фан Вэнь-лань, УХань, Мэн Сы-мэн, Ван Чун-у, Юн Юань-ань, Шан Юэ и др.

Однако, с 1961 года начали открыто высказываться взгляды о необходимости пересмотра отрицательного отношения к монгольскому владычеству в Китае, на что обращает внимание крупный советский китаевед С. Л. Тихвинский в своей известной работе «Татаро-монгольские завоевания в Азии и Европе». Так например, в 1961 году на страницах «Жэнь минь жибао» появилась статья, где было сказано, что империя, созданная Чингис-хаганом, сыграла прогрессивную роль в истории Китая, и что он восстановил вновь великое национальное государство, которого не было со времени династии Хань и Тан и т. д.

В той же статье включены все территории вплоть до берегов Средиземного моря, завоеванные монголами во время их походов в состав Китайской империи.

В 1962 г. центральная печать КНР опубликовала восторженный отзыв об основателе монгольской династии Юань в Китае. В феврале-апреле 1962 г. в центральном китайском историческом журнале «Лиши яньцзю» одна за другой появились статьи посвященные Чингис-хагану и проблеме монгольского владычества в Китае.

При анализе вышеназванных статей нетрудно видеть, что их основная цель заключается в «научном» обосновании великодержавно-щовинистических замыслов современных пекинских лидеров в отношении других стран.

Автор далее пишет, что маоистские историки, пересматривая историю Китая и выдвигая версию о так называемом поочередном управлении Китаем различными представителями мнимой «срединной нации», пытаются утверждать, что некитайские народы, входящие ныне в состав КНР и соседние с Китаем народы, в том числе и монгольский народ, как будто являются исконными составными частями Китая. Подобная анти научная концепция попирает национальные права народов внутри самого Китая и посягает на государственную независимость соседних стран и народов.